



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Ш.РАДНААСЭД ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2017.12.20 № 01/2203  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолын төсөл хүргүүлэх тухай

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасны дагуу "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан танилцуулгын хамт үүгээр Танд хүргүүлж байна.

Тогтоолын төслийг хянан үзэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ

018260

## ТАНИЛЦУУЛГА

### Албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох талаар

Байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүгийн боломжит хэмжээнд бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг “Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэсэн заалтыг хангуулахаар “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

2006 онд Авлигын эсрэг хууль батлагдсанаар 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, албан хаагчдын цалингийн хэмжээг тогтоохдоо бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор адил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг төрийн бусад байгууллагын албан хаагчийн сарын цалингийн хэмжээнээс 50-60 хувь өндөр байх жишгийг баримталсан байдаг бөгөөд өнөөгийн байдлаар дээрх жишиг илүү урвуугаар тогтоогдоод байна.

2014 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг нэмсэн бөгөөд Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт зааснаар тус газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг Монгол Улсын Их Хурлаас тогтоодог учраас цалин нэмэгдээгүй, Монгол Улсын Их Хурлын 2011 оны 55 дугаар тогтоолоор тогтоосон хэмжээгээр байгаа болно.

Өнөөдрийн байдлаар Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын сарын цалинг үйл ажиллагаа нь уялдаатай явагддаг хууль хяналтын хоёр байгууллагын албан тушаалын сарын цалинтай харьцуулан үзэхэд прокурорын албан тушаалын цалин 60-70 хувиар өндөр, шүүгчийн хувьд 1.4-1.7 дахин их хэмжээгээр илүү байна.

Прокурор болон шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоохдоо өмнөх цалингийн хэмжээнээс 2-3 дахин нэмэгдүүлэн тогтоосон байна.

Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоохдоо батлагдсан төсвийн хэмжээг харгалзан 2018 оны төсөвт батлагдсан цалингийн сандаа багтаан 30 хувиар нэмэгдүүлэн тооцлоо.

Түүнчлэн “Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журамд тус газарт 1-ээс дээш жил ажилласан хэлтэс, албаны туслах ажилтанд дэд комиссар зэрэг дэв олгохоор тогтоосон.

Харин 2011 онд цалингийн хэмжээ тогтоохдоо туслах ажилтан /жолооч, бичиг хүргэгч г.м/-ы цалинг орхигдуулсан байсныг жагсаалтад нэмж тусгасан болно. Туслах ажилтны цалинг төрийн “ТГ” ангилал зэрэглэлийн адил төстэй чиг үүрэг

гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийн цалингийн хэмжээтэй дүйцүүлэн тоцон олгож байсан бөгөөд цаашид туслах ажилтны нийгмийн баталгаа, хангамж болон тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлыг зохицуулахад цалингийн хэмжээг нь хуульд заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрт тусган тогтоолгох зайлшгүй шаардлага үүсч байгаа болно.

Энэ онд тус газрын албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тогтоож, хэлтэс, албаны туслах ажилтныг жагсаалтанд нэмж оруулснаар төсвөөс ямар нэгэн нэмэлт санхүүжилт шаардагдахгүй бөгөөд байгууллагын 2018 оны төсвийн нийт зардалдаа багтаан зохицуулах боломжтой.

---000---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын  
цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Цаашид төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг Засгийн газраас шинэчлэн тогтоох бүрд цалинг нэмэгдүүлсэн хэмжээгээр нь тооцон олгож байхыг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТӨСӨЛ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны  
.....дугаар тогтоолын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН  
ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН  
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| Д/д | Албан тушаал                      | Албан тушаалын сарын<br>цалингийн хэмжээ /<br>төгрөгөөр/ |
|-----|-----------------------------------|--|
| 1.  | Авлигатай тэмцэх газрын дарга     | 1 833 600  |
| 2.  | Авлигатай тэмцэх газрын дэд дарга | 1 708 000  |
| 3.  | Хэлтсийн дарга                    | 1 637 430  |
| 4.  | Албаны дарга                      | 1 551 200  |
| 5.  | Ахлах ажилтан                     | 1 421 800  |
| 6.  | Ажилтан                           | 1 292 400  |
| 7.  | Туслах ажилтан                    | 795 000  |